



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/58

Чийгбалсан

Шинэ коронавирусийн халдвараас
урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлыг
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.5 "в", Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн, 32.1.1, 32.1.3, 32.1.8, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 16.1.2, 18.1.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн шийдвэр, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 242 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 19 дүгээр албан даалгавар, аймгийн Онцгой комиссын 2020 оны 02 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 3 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусийн халдвар /2019 nCoV/ болон томуу, томуу төст өвчний үед болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв /Д.Должин/, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

2. Хүүхдийг эмнэлгийн орчноос халдвар авахаас сэргийлж дуудлагын утас ажиллуулах, яаралтай тусламжийн эмч, жолооч, автомашины тоог нэмэгдүүлэх, хүүхдийн амбулаторийн үзлэгийг гэрийн эргэлтэд шилжүүлж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв /Д.Должин/, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

3. Шинэ коронавирусийн халдвар зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэлт нөхцөл байдалд тухай бүр эрсдлийн түргэвчилсэн үнэлгээ хийж, хариу арга хэмжээ зохион байгуулахыг аймгийн Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/, Бүсийн оношилгоо эмчилгээний төв /Д.Должин/, Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтуяа/-т тус тус үүрэг болгосугай.

010120137

4.Хилийн боомтуудад хамтарсан ажлын хэсэг ажиллуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, боомтод ариутгал халдваргүйжүүлэлт тогтмол хийх, нэг удаагийн халдваргүйтгэлийн хувцас хэрэгслээр хангах, хилээр зорчигчдын халууныг хэмжих, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль, журмын дагуу тусгаарлах, яаралтай арга хэмжээ авч ажиллахыг Хилийн ...дугаар анги /Хурандаа О.Батгэрэл, Хурандаа Ж.Эрдэнэчулуун/, аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтуяа/, Гаалийн газар /П.Одсүрэн/, Тагнуулын газар /Б.Бямбаа/, Гадаадын иргэн харьяатын Зүүн бүс дэх газар /Б.Тамир/, Чойбалсан Олон улсын нисэх буудал /М.Энхтөр/, Зүүн бүсийн төв Онцгой байдлын газар /Г.Нармандах/, Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/-т тус тус даалгасугай.

5.Хилийн цаана байгаа Монгол Улсын иргэдэд хилийн боомтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг шуурхай хүргэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс /Ц.Баяржаргал/, Хилийн ...дугаар анги /Хурандаа О.Батгэрэл, Хурандаа Ж.Эрдэнэчулуун/, Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтуяа/, Гаалийн газар /П.Одсүрэн/, Тагнуулын газар /Б.Бямбаа/-т тус тус үүрэг болгосугай.

6.Хилийн боомтоор зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд Засгийн газрын шийдвэр, Улсын Онцгой комиссын шийдвэр, аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу хязгаарлалт хийж ажиллахыг Авто тээврийн төв /Ц.Мөнхтөр/, Гаалийн газар /П.Одсүрэн/, Хилийн ...дугаар анги /Хурандаа О.Батгэрэл, Хурандаа Ж.Эрдэнэчулуун/, аялал жуулчлалын компаниудад хилийн боомтууд дахь хязгаарлалтын талаар мэдээлэл хүргэж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Б.Эрдэнэбаяр/-т тус тус үүрэг болгосугай.

7.Хязгаарлалт тогтоосон 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, хурал зөвлөгөөн, соёл урлагийн арга хэмжээ, сургалтын төв, жолооны дамжаа, дугуйлан секц, цахим тоглоомын газруудын үйл ажиллагааг хориглох, зарлагдсан арга хэмжээнүүдийг цуцлах, олон нийтэд мэдээлж ажиллахыг сумын Засаг дарга нар, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар /А.Нансалмаа/, Биеийн тамир, спортын газар /Б.Чимэддорж/, Хөгжимт драмын театр /Л.Наранхүү/, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /Н.Мөнхгэрэл/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Э.Жавхлан/-т, оройн цагаар ажиллаж байгаа караоке, зоог, цэнгээний газруудын ажиллах цагийн хуваарьт хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга, Цагдаагийн газар /Т.Ганзориг/-т тус тус үүрэг болгосугай.

8.Заасан хугацаанд сургалтын хөтөлбөрийн агуулгын дагуу теле болон цахим хичээл, сургалт, багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг оновчтой хэлбэрээр зохион байгуулахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар /А.Нансалмаа/, Дорнод Их сургууль /Э.Ундармаа/, Дорнод Политехникийн коллеж /Г.Сүмбэр/, Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв /Н.Хүрэлбаатар/, Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад, цэцэрлэгийн багш албан хаагчдыг хууль тогтоомжид нийцүүлэн амраахыг сумын Засаг дарга, Боловсрол, соёл, урлагийн газар /А.Нансалмаа/, цэцэрлэгийн эрхлэгч нарт тус тус даалгасугай.

9.Хязгаарлалт тогтоосон 2020 оны 03 дугаарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд томуугаар өвчилсөн 0-5 насны хүүхдээ эмнэлэгт болон гэрээр 5 хүртэлх хоног асарсан эцэг, эхчүүдэд цалинтай чөлөө олгох, ажил эрхэлж буй жирэмжсэн эхчүүдэд цалинтай чөлөө болон ээлжийн амралт олгох, ажлыг бусад ажилтанд хавсран гүйцэтгүүлж ажиллуулахыг Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

10.Худалдаа үйлчилгээний төв, зах, иргэдэд үйлчилдэг бусад худалдаа, үйлчилгээний байгууллагуудад ариутгал халдваргүйтгэл хийхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч дэмжлэгт хяналт хийж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтуяа/, Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа /-т тус тус даалгасугай.

11.Эмийн сан, эм ханган нийлүүлэх төв, зах, хүнсний дэлгүүрүүдэд эм, эмнэлгийн хэрэгсэл, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнд үнийн өсөлт гарч буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс /Ц.Баяржаргал/, Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтуяа/, Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/-т тус тус үүрэг болгосугай.

12.Айл өрх, аж ахуйн нэгж, албан байгууллага бүр эрүүл мэндийн байгууллагаас өгч буй зөвлөмжийн хүрээнд агааржуулалт, цэвэрлэгээ ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийж, ажилтан албан хаагчдаа амны хаалтаар ханган ажиллахыг аж ахуйн нэгж, албан байгууллагуудын удирдлагуудад уриалсугай.

13.Эрүүл мэндийн яамнаас гаргаж буй зөвлөмжийг хэрэгжүүлж, онц шаардлагагүй тохиолдолд бага насны хүүхдийг гадуур гаргахгүй болон олон нийтийн газраар дагуулж явахгүй байх, амны хаалт хэрэглэхийг нийт ард иргэдэд уриалсугай.

14.Өдөр бүр Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн яамнаас мэдээлж буй албан мэдээг санал дүгнэлтийн хамт аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/-т даалгасугай.

15.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ч.Ганбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  М.БАДАМСҮРЭН